



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн “Гэр бүлийн ордон” ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлангийн
аудитын хураангуй тайлан

Аудитын код: ОРА-2024/07/НА-СТА-ОНА

Цахим хуудас:
www.audit.mn

Орхон аймаг
2024 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах
Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Буян-ундрах
Утас: 70355805 Цахим хаяг: Буynundrakhb@audit.gov.mn

Аудитор: Ж.Наранчимэг
Утас: 70359826 Цахим хаяг: naranchimegj@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт /Баталгаажсан хувийг оруулах/



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2024.03.15 № 84
танай _____-ны № _____-т

ОРХОН АЙМГИЙН ГЭР БҮЛИЙН
ОРДОН ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ
Б.ГАНЧИМЭГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Орхон аймгийн "Гэр бүлийн ордон" ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Орхон аймгийн "Гэр бүлийн ордон" ОНӨААТҮГ-ын оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

2023 онд тус байгууллагын үндсэн үйл ажиллагаа болох хурим найр, тэнгэрлэг гэр бүлийн хүндэтгэл, дархан, уран бэрийн шагнал гардуулах зэрэг үйл ажиллагаа хэвийн явагдсан ч COVID-19 цар тахлын улмаас өмнөх онуудад үйл ажиллагааны орлого тасарч байр ашиглалт болон ажилчдын цалинтай холбоотой үүссэн өр төлбөрүүд төлөгдөөгүй байна.

Аудитын гол асуудал

Орхон аймгийн "Гэр бүлийн ордон" ОНӨААТҮГ-аар нь ерөнхий боловсролын сургуулийн 11, 12 дугаар ангийн сурагчдын дунд "Зөв хүүхэд зөв хөгжил" сургалт зохион байгуулахаар төлөвлөн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд сургалтад шаардлагатай төсвийг боловсруулан танилцуулж 5,315.9 мянган төгрөгийн дэмжлэг авч, аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлтэй хамтран 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдөр 11, 12 дугаар ангийн 68 сурагчдад сургалт зохион байгуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Орхон аймгийн “Гэр бүлийн ордон” ОНӨААТҮГазар нь 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 3 зорилтын хүрээнд, 10 арга хэмжээг хэрэгжүүлэхээр Орхон аймгийн Засаг даргатай байгуулж хэрэгжилтийг хангалтгүй гэж үнэлсэн байна.

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй төрийн аудитын албан хаагчид аливаа этгээдийн нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	42,819,706.46	38,790,746.87
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	391,941.68	69,021.16
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	388,483.74	16,450.00
3121	Төгрөг	388,483.74	16,450.00
33	АВЛАГА	15,937,174.90	15,386,850.40
335	Бусад авлага	15,937,174.40	15,386,850.40
3351	Байгууллагаас авах авлага	15,937,174.40	15,203,305.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага		183,545.40
35	БАРАА МАТЕРИАЛ	26,307,044.48	23,334,875.31
351	Түүхий эд материал	26,307,044.48	23,334,875.31
354	Хангамжийн материал	26,307,044.48	23,334,875.31
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	9,528,886.21	7,292,535.99
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	9,528,886.21	7,292,535.99
392	Биет хөрөнгө	9,528,886.21	7,292,535.99
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	13,125,299.98	13,125,299.98
39206	Хуримтлагдсан элэгдэл	(10,852,592.87)	(11,515,115.97)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	44,870,414.83	44,870,414.83
39208	Хуримтлагдсан элэгдэл	(37,614,235.73)	(39,188,062.85)
393	Биет бус хөрөнгө	2,132,454.55	2,132,454.55
39301	Програм хангамж	(2,132,454.55)	(2,132,454.55)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	52,348,592.67	46,083,282.86
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	89,573,182.25	72,667,407.79
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	89,573,182.25	72,667,407.79
413	Өглөг	-	72,667,407.79
4136	Бусад өглөг	-	72,667,407.79
41361	Байгууллагад төлөх өглөг	-	12,613,333.90
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	3,224,386.84
41363	Татварын өглөг /ТӨҮГ/		32,109,388.03
41364	НДШ - ийн өглөг /ТӨҮГ/		24,720,299.02
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	(37,224,589.58)	(26,584,124.93)
51	Засгийн газрын хувь оролцоо	(37,224,589.58)	(26,584,124.93)
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	48,067,037.80	48,067,037.80
51101	Өмч: - төрийн	43,554,506.00	43,554,506.00
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	4,512,531.80	4,512,531.80
512	Хуримтлагдсан үр дүн	(88,931,327.38)	(78,290,862.73)
51210	Өмнөх үеийн үр дүн	(71,764,192.54)	(54,644,661.92)
51220	Тайлант үеийн үр дүн	(17,167,134.84)	(23,646,200.81)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,639,700.00	3,639,700.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	52,348,592.67	46,083,282.86

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	77,642,779.27	106,555,371.20
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	77,642,779.27	106,555,371.20
120	Нийтлэг татварын бус орлого	77,642,779.27	106,555,371.20
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	30,519,988.30	
120010	Борлуулалтын орлого (цэвэр) /ТӨҮГ/	47,122,790.97	106,555,371.20
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	94,809,914.11	130,201,572.01
21	УРСГАЛ ЗАРДАЛ	94,809,914.11	130,201,572.01
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	94,809,914.11	130,201,572.01
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	92,335,530.23	127,965,221.79
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	92,355,530.23	127,965,221.79
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,474,383.88	2,236,350.22
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	2,474,383.88	2,236,350.22
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(17,167,134.84)</u>	<u>(23,646,200.81)</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(17,167,134.84)</u>	<u>(23,646,200.81)</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>83,406,664.00</u>	<u>114,993,725.26</u>
11	ТАТВАРЫН ОРЛОГО	83,406,664.00	114,993,725.26
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	83,406,664.00	114,993,725.26
120	Нийтлэг татварын бус орлого	83,406,664.00	114,993,725.26
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>83,060,517.81</u>	<u>115,316,645.78</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	83,060,517.81	115,316,645.78
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	83,060,517.81	115,316,645.78
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	37,102,746.20	60,036,410.85
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	37,102,746.20	60,036,410.85
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,183,959.87	6,399,572.93
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	1,183,959.87	6,399,572.93
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,867,090.63	18,014,482.00
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	9,867,090.63	18,014,482.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,497,144.00	20,703,130.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,497,144.00	20,703,130.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	26,550,000.00	40,148,896.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	550,000.00	-

210604	Урсгал засвар	26,000,000.00	40,148,896.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,494,339.86	10,163,050.00
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	36,500.00	499,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,915,237.25	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,915,237.25	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>346,146.19</u>	<u>(322,920.52)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	346,146.19	(322,920.52)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		391,941.68
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	391,941.68	69,021.16

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	48,067,037.80	3,639,700.00	(71,764,192.54)	(20,057,454.74)
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	48,067,037.80	3,639,700.00	(71,764,192.54)	(20,057,454.74)
Тайлант үеийн үр дүн	-	-	(17,167,134.84)	(17,167,134.84)
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	48,067,037.80	3,639,700.00	(88,931,327.38)	(37,224,589.58)
2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	48,067,037.80	3,639,700.00	(88,931,327.38)	(37,224,589.58)
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	34,286,665.46	34,286,665.46
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	48,067,037.80	3,639,700.00	(54,644,661.92)	(2,937,924.12)
Тайлант үеийн үр дүн	-	-	(23,646,200.81)	(23,646,200.81)
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	48,067,037.80	3,639,700.00	(78,290,862.73)	(26,584,124.93)

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Борлуулалтын орлого	99,045,000.00	106,486,350.04
2	Нийт зардал	98,315,644.00	130,201,572.01
3	Татвар ногдох орлого	729,356.00	0
4	Татвар 10%	72,935.60	0
5	Цэвэр ашиг	656,420.40	/23,646,200.81/
6	Тайлант үеийн ашиг, алдагдал	656,420.40	/23,646,200.81/

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 794.0 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс 155.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 639.0 мянган төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж өгсөн.

3.1 Төлбөрийн акт

Тайлант онд "Зөв хүүхэд-зөв хөгжил" сургалтын 2 багшид ажлын хөлс шилжүүлэхдээ ХХОАТ суутгаагүйд төлбөрийн акт тогтоов.

3.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөөгүй.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд цахим төлбөрийн баримтгүй 639.0 мянган төгрөгийн гүйлгээ хийсэн байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28.5-д "...дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй.", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цахим төлбөрийн баримтыг үндэслэж гүйлгээ хийж байх.

2. Бараа материалын орлого, зарлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Бараа материалын анхан шатны баримт шаардах хуудас бичсэн болон хүлээн авсан ажилтны гарын үсгийн бүрдэл хангалтгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримтын бүрдлийг ханган ажиллаж, баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэл тайланд тусгахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тайлант онд "Зөв хүүхэд-зөв хөгжил" сургалтад багшаар ажилласан 2 багшид ажлын хөлс шилжүүлэхэд ХХОАТ-н суутгал хийлгүй 155,000 төгрөг илүү олгосон байна.	1	155.0	1	155.0								
Тайлант онд цахим төлбөрийн баримтгүй 639.0 мянган төгрөгийн гүйлгээ хийсэн байна.	1	639.0					1	639.0				
Бараа материалын анхан шатны баримт шаардах хуудас бичсэн болон хүлээн авсан ажилтны гарын үсгийн бүрдэл хангалтгүй байна.	1	0					1	0				
Дүн	3	794.0	1	155.0			2	639.0				